

ЗЭЭЛИЙН ДУГААР: 201813470

ЗЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭР: БНХАУ ЭКСПОРТ-ИМПОРТ БАНК

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл”

САНГИЙН ЯАМ

/зээлдүүлэгч/

БА

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

/дэд зээлдэгч/

БОЛОН

“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК


/эцсийн зээлдэгч/

ХООРОНД БАЙГУУЛСАН

ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЫ ӨДӨР

БАТЛАВ:



“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ ТӨСӨЛ” –ИЙН
ЗЭЭЛЛЭГИЙН ХӨРӨНГИЙГ ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

2024 оны 12 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар 223/318/36/2024/ Улаанбаатар хот
ЕРД/24/51

Энэхүү гэрээг нэг талаас САНГИЙН ЯАМ /цаашид “Зээлдүүлэгч” гэх/, нөгөө талаас ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ /цаашид “Дэд зээлдэгч” гэх/, ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК /цаашид “Эцсийн зээлдэгч” гэх/ харилцан тохиролцож, Иргэний хуулийн 281-284 дүгээр заалт, Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 211 дугаартай тогтоолоор батлагдсан “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам”, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк болон Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам хооронд байгуулсан 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Эрдэнэтийн дулааны цахилган станцын өргөтгөл төсөл”-ийн гадаад зээллэгийн гэрээг үндэслэн байгуулав.

Ерөнхий зүйл

(А) Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк /цаашид “Банк” гэх/ хооронд 2018 оны 04 дүгээр сарын 9-ний өдөр байгуулагдсан зээллэгийн гэрээний дагуу Банк нь Монгол Улсад дээрх зээллэгийн гэрээнд тусгагдсан нөхцөл, болзлын дагуу 51,800,000.0 /тавин нэгэн сая найман зуун мянга/ ам.доллартай тэнцэх зээллэгийн эх үүсвэрийг олгохоор тохиролцсон.

(Б) Засгийн газрын шугамаар авсан гадаад зээллэгийг эргүүлэн төлөх дотоод эх үүсвэрийг бүрдүүлэх, зээллэгийн гэрээнд тодорхойлсны дагуу “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл” /цаашид “Төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхэд эцсийн зээлдэгчид энэхүү гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлнэ.

(В) Зээллэгийн гэрээ ба “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам”-д тодорхойлсон нэр томъёоны утга агуулга нь уг

Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдүүлэгчийг төлөөлж:

Зээлдэгчийг төлөөлж:

баримт бичгүүдэд тодорхойлсон утга агуулгаа энэхүү дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд нэгэн адил хадгална.

(Г) Энэхүү гэрээний хавсралт нь түүний салшгүй хэсэг мөн.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Дамжуулан зээлдүүлэх ерөнхий нөхцөл

1.1. Зээлдүүлэгч нь зээллэгийн хөрөнгийг дараах нөхцөл болзлын дагуу эцсийн зээлдэгчид дамжуулан зээлдүүлнэ:

- 1.1.1. **Зээлийн дүн:** 51,800,000.0 /тавин нэгэн сая найман зуун мянга/ ам.доллар байна;
- 1.1.2. **Зээлийн хүү болон эрсдэлийн шимтгэл:** Жилийн нийт 2.75 нэгж хувь байна.
- 1.1.3. **Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж:** Жилийн 0.25 нэгж хувь байх бөгөөд БНХАУ Экспорт-Импорт банкаас ирүүлсэн нэхэмжлэлийн дүнгээр тооцно.
- 1.1.4. **Төлбөр төлөх огноо:** Зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүү, шимтгэлийн төлбөрийг жил бүрийн 5 дугаар сарын 21 ба 11 дүгээр сарын 21-ний өдөр зээлдүүлэгчид төлнө;
- 1.1.5. **Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа:** Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа гадаад зээллэгийн гэрээ байгуулагдсанаас хойш 7 жил буюу 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийг хүртэл байна.
- 1.1.6. **Зээлийг төлж барагдуулах хугацаа:** 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 2037 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл байна;
- 1.1.7. **Зээлийн үндсэн, хүү, шимтгэлийн төлбөрийг тооцох хоног:** Жилийн 360 хоног, сарын 30 хоногоор тооцно;
- 1.1.8. **Алданги:** Хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувь;
- 1.1.9. Алдангийг үндсэн болон хүүгийн төлбөрөөс тооцно.

1.2. Энэхүү гэрээний аливаа заалтыг харгалзахгүйгээр зээлийн хэлэлцээрийн дагуу төсөлд зориулж хөрөнгө, эх үүсвэр шилжүүлж авах зээлдүүлэгчийн эрх бүхлээр буюу хэсэгчлэн зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болох тохиолдолд зээлдэгчийн зээлийн хөрөнгө, эх үүсвэр хүлээн авах эрх нэгэн адил зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болно.

Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдүүлэгчийг төлөөлж:



Зээлдэгчийг төлөөлж:



ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Зээлийн эргэн төлөлтийг гүйцэтгэх

2.1. Эцсийн зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг энэхүү гэрээний хавсралтад дурдсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу дараах зарчмыг баримтлан төлнө:

2.1.1. Зээлийн эргэн төлөлтийг Төрийн сан дахь “Дамжуулан зээлийн төлбөр” 100 900000 711 тоот дансанд шилжүүлэх бөгөөд нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу дансны хуулгыг үндэслэн бүртгэл тооцоог хөтөлнө;

2.1.2. Зээлийн төлбөрийг тухайн зээлийн ашиглалт гарсан өдрийн нэг өдрийн өмнөх Монголбанкны хаалтын ханшийг ашиглан төлнө;

2.1.3. Үндсэн болон хүүгийн төлбөрийг тус тусдаа гүйлгээгээр дараах товчилсон утгаар шилжүүлнэ:

2.1.3.1. Үндсэн төлбөрийг төлөхдөө “201813470-11” гэж;

2.1.3.2. Хүүгийн болон шимтгэлийн төлбөрийг төлөхдөө

“201813470-21” гэж;

2.2. Эцсийн зээлдэгч нь энэхүү гэрээгээр авсан зээлийн хөрөнгийг хугацаанаас нь өмнө буцааж төлөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд зээлийг урьдчилж төлөх тухай мэдэгдлийг төлбөр хийхээс 30 хоногийн өмнө зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Зээлдүүлэгчийн эрх үүрэг

3.1. Зээлдүүлэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулахын зэрэгцээ эцсийн зээлдэгчийн төсөл хэрэгжүүлэх зорилгоор энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд зээлдүүлэгчээс хамаарах бүхий л үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

3.2. Энэхүү гэрээний 2.1-д заасны дагуу хүлээсэн үүргээ бүрэн, эсвэл хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алданги тооцож, эцсийн зээлдэгчийн Төрийн банкны 130400024491 тоот данснаас үл маргах журмаар шууд суутган авах эрхтэй.

3.3. Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг дор дурдсан дарааллаар хасалт хийж тооцно. Үүнд:

3.3.1. Алданги;

3.3.2. Хүүгийн болон эрсдэлийн шимтгэлийн төлбөр;

3.3.3. Үндсэн төлбөр.

Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдүүлэгчийг төлөөлж:



Зээлдэгчийг төлөөлж:



3.4. Эцсийн зээлдэгч зээлийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах, зээлийн төлбөрийг дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон гадаад зээллэгийн гэрээ, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зээлийг хэсэгчлэн эсвэл бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар хүргүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.5. Хэрэв Монгол Улсын Засгийн газраас дэд болон эцсийн зээлдэгчид татаас, санхүүжилт, татварын хөнгөлөлт болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиолдолд энэхүү дэмжлэгээс дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний 3.3-т заасан дарааллыг баримтлан зээлийн хугацаа хэтэрсэн төлбөрийг суутган тооцож, төсөвт төвлөрүүлж болно.

3.6. Энэ гэрээний хүрээнд зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих, эцсийн зээлдэгчтэй улирал болгон тооцоо нийлэх, зээлийн үлдэгдлийн дүнг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

3.7. Эцсийн зээлдэгч дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлээгүй тохиолдолд зээлдүүлэгч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6.1, 32.6.2-т заасны дагуу арга хэмжээг авна.

3.8. Зээлдүүлэгч энэхүү гэрээгээр олгож буй зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх эрхтэй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ **Дэд зээлдэгчийн эрх үүрэг**

4.1. Дэд зээлдэгч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан нийтлэг үүргээс гадна энэ зүйлд заасан тусгайлсан эрх, үүргийг хүлээнэ.

4.2. Дэд зээлдэгч нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг эцсийн зээлдэгчээр төлүүлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3. Дэд зээлдэгч нь эцсийн зээлдэгчийн зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд хяналт тавина.

4.4. Гадаад зээллэгийн эх үүсвэрээр худалдан авсан хөрөнгийг эцсийн зээлдэгчид тогтвортой эзэмшүүлж ашиглуулах замаар орлогын эх үүсвэр, хуримтлал бий болгох бодлого баримталж, бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

4.5. Эцсийн зээлдэгч үүсгэн байгуулагдсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй хуульд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүний төлбөрийн үүргийг нэн даруй

Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдүүлэгчийг төлөөлж:



Зээлдэгчийг төлөөлж:



гүйцэтгүүлэх, татан буугдах тохиолдолд өр төлбөрийг холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээг авна.

4.6. Зээлдүүлэгчийн өмнө эцсийн зээлдэгчийн нэгэн адил үүрэг, хариуцлага хүлээнэ.

4.7. Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.

4.8. Дэд зээлдэгч нь уг гэрээний эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ТАВДУГААР ЗҮЙЛ **Эцсийн зээлдэгчийн эрх үүрэг**

5.1. Эцсийн зээлдэгчийн нэр, байнгын хаяг:

ЗЭЭЛДЭГЧИЙН НЭР: “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК

ХАЯГ: Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Баянцагаан баг, Өөрийн байр

Утас: 70350951

Факс: 70353718

Цахим хуудас: erdenetpp.mn

И-мэйл хаяг: info@erdenetpp.mn

5.2. Эцсийн зээлдэгч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасан нийтлэг үүргээс гадна энэ зүйлд заасан тусгайлсан эрх, үүргийг хүлээнэ.

5.3. Эцсийн зээлдэгч нь хариуцсан төслийг удирдлага, зохион байгуулалт, санхүү, инженер техник, байгаль орчин болон олон улсын стандартын хэм хэмжээний хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.4. Буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирол болон гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргийг эцсийн зээлдэгч бүрэн хариуцна.


5.5. Зээлийн эргэн төлөлтөөс ханшийн зөрүү үүссэн тохиолдолд эцсийн зээлдэгч бүрэн хариуцна.

5.6. Эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон хөрөнгийг зөвхөн гадаад зээллэгийн гэрээнд заасан төслийн зориулалтаар ашиглана.

5.7. Зээлийн данснаас шилжүүлсэн төлбөрийг хүлээн авах тухай бүрд бодитоор гарсан зардлын анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл тайланд тусгана.

Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдүүлэгчийг төлөөлж:



Зээлдэгчийг төлөөлж:



5.8. Эцсийн зээлдэгч нь зээлийн эх үүсвэрээр авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд зээлийн хөрөнгийг өөр зориулалтаар захиран зарцуулахыг хориглоно.

5.9. Гадаад зээллэгийн шугамаар нийлүүлэгдсэн, бий болсон эд хөрөнгө, тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын ашиглалт, арчлалт, элэгдэл, хадгалалт, засвар үйлчилгээг эцсийн зээлдэгч бүрэн хариуцах ба ашигласан зээлийн үлдэгдэлд оруулж тооцохгүй.

5.10. Эцсийн зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд тайлан тэнцэлдээ хөрөнгөөр бүртгэж, дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл ашигласан зээлийн дүнг тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэнэ.

5.11. Эцсийн зээлдэгчийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг жил бүр байгууллагын төсөвт суулгаж, эргүүлэн төлөх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

5.12. Байгууллагын төсөвт тусгагдаагүй шалтгаан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 31, 32 дугаар зүйлд заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг гүйцэтгэхгүй байх үндэслэл болохгүй.

5.13. Гадаад зээллэгийн шугамаар нийлүүлэгдсэн, бий болсон эд хөрөнгө, тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг цааш гуравдагч этгээдэд борлуулж, нийлүүлж чадаагүй нь дамжуулан зээлдүүлэх зээлийг эргэн төлөхгүй байх үндэслэл болохгүй ба эцсийн зээлдэгч үйл ажиллагааны орлогоос зээлийн үндсэн болон хүү, шимтгэлийн төлбөрийг төлөх үүрэгтэй.


5.14. Эцсийн зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр зээлдүүлэгчид албан бичгээр мэдэгдэж хагас жил тутам тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй.

5.15. Эцсийн зээлдэгч үүсгэн байгуулагдсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн өрийн төлөгдөөгүй үлдэгдэл, тухайн үед хуримтлагдсан бүх хүүг нэн даруй зээлдүүлэгчид төлнө.

5.16. Эцсийн зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаарх тайлан танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг хүлээн авсан нийлүүлэлт, үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр зээлдүүлэгчид ирүүлнэ.

Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдүүлэгчийг төлөөлж:



Зээлдэгчийг төлөөлж:



ЗУРГАДУГААР ЗҮЙЛ Маргааныг шийдвэрлэх

6.1. Зээлдүүлэгч болон эцсийн зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв ийм шугамаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ДОЛДУГААР ЗҮЙЛ Хүчин төгөлдөр, дуусгавар болох

7.1. Энэхүү гэрээ нь оролцогч талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба 4 хувь үйлдэнэ.

7.2. Зээлдүүлэгч холбогдох яам, газартай хамтран энэхүү гэрээг дүгнэж, эцсийн зээлдэгч уг зээлтэй холбогдох ямар нэг өр төлбөргүй болохыг тодорхойлсон дүгнэлт гаргаж, зээлийг хаасан тухай зээлдүүлэгчийн мэдэгдлийг эцсийн зээлдэгчид хүргүүлснээр энэхүү дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болсонд тооцно.

7.3. Эцсийн зээлдэгч нь өөрчлөн байгуулагдах тохиолдолд түүний энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүрэг нь ийнхүү өөрчлөн байгуулагдсаны дүнд шинээр үүссэн хуулийн этгээдэд шилжинэ.

НАЙМДУГААР ЗҮЙЛ Бусад

8.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлээр зохицуулах бөгөөд дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг тайлан тэнцэлд зайлшгүй тусгана.

8.2. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор эцсийн зээлдэгч нь зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэхийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ЗЭЭЛДҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ж.ГАНБАТ
САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ДЭД ЗЭЭЛДЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Н.ТАВИНБЭХ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Хуудсыг баталгаажуулсан:


Зээлдүүлэгчийг төлөөлж:



Зээлдэгчийг төлөөлж:




 З.ЭНХБОЛД
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
 ДАРГА


 Г.ЭРХЭМБАЯР
 ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
 ДАРГА


 Л.СОНОР
 САНХҮҮГИЙН БОДЛОГЫН
 ГАЗРЫН ДАРГА


 О.ХУЯГЦОГТ
 САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
 ГАЗРЫН ДАРГА


ЭЦСИЙН ЗЭЭЛДЭГЧИЙГ
 ТӨЛӨӨЛЖ:


 Б.БАТ-ЭРДЭНЭ
 “ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
 ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


 Б.СУРМААХОРОЛ
 “ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
 ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
 ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


 Б.ЗУЛЦЭЦЭГ
 “ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
 ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Зээлдүүлэгчийг төлөөлж:



Хуудсыг баталгаажуулсан:

Зээлдэгчийг төлөөлж:



Сангийн яам болон "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК хооронд байгуулсан "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл"-ийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хавсралт

1

Зээлийн эргэн төлөлтийн хуваарь

Зээлийн дүн: 51,800,000.00

Зээлийн хүү: 2.75%

/ам.доллар/

Огноо	Хоног	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үлдэгдэл
2024-12-31					51,800,000.00
2025-05-21	141.00	1,760,000.00	557,929.17	2,317,929.17	50,040,000.00
2025-11-21	180.00	1,760,000.00	688,050.00	2,448,050.00	48,280,000.00
2026-05-21	180.00	2,000,000.00	663,850.00	2,663,850.00	46,280,000.00
2026-11-21	180.00	2,000,000.00	636,350.00	2,636,350.00	44,280,000.00
2027-05-21	180.00	2,000,000.00	608,850.00	2,608,850.00	42,280,000.00
2027-11-21	180.00	2,000,000.00	581,350.00	2,581,350.00	40,280,000.00
2028-05-21	180.00	2,000,000.00	553,850.00	2,553,850.00	38,280,000.00
2028-11-21	180.00	2,000,000.00	526,350.00	2,526,350.00	36,280,000.00
2029-05-21	180.00	2,000,000.00	498,850.00	2,498,850.00	34,280,000.00
2029-11-21	180.00	2,000,000.00	471,350.00	2,471,350.00	32,280,000.00
2030-05-21	180.00	2,000,000.00	443,850.00	2,443,850.00	30,280,000.00
2030-11-21	180.00	2,000,000.00	416,350.00	2,416,350.00	28,280,000.00
2031-05-21	180.00	2,020,000.00	388,850.00	2,408,850.00	26,260,000.00
2031-11-21	180.00	2,020,000.00	361,075.00	2,381,075.00	24,240,000.00
2032-05-21	180.00	2,020,000.00	333,300.00	2,353,300.00	22,220,000.00
2032-11-21	180.00	2,020,000.00	305,525.00	2,325,525.00	20,200,000.00
2033-05-21	180.00	2,020,000.00	277,750.00	2,297,750.00	18,180,000.00
2033-11-21	180.00	2,020,000.00	249,975.00	2,269,975.00	16,160,000.00
2034-05-21	180.00	2,020,000.00	222,200.00	2,242,200.00	14,140,000.00
2034-11-21	180.00	2,020,000.00	194,425.00	2,214,425.00	12,120,000.00
2035-05-21	180.00	2,020,000.00	166,650.00	2,186,650.00	10,100,000.00
2035-11-21	180.00	2,020,000.00	138,875.00	2,158,875.00	8,080,000.00
2036-05-21	180.00	2,020,000.00	111,100.00	2,131,100.00	6,060,000.00
2036-11-21	180.00	2,020,000.00	83,325.00	2,103,325.00	4,040,000.00
2037-05-21	180.00	2,020,000.00	55,550.00	2,075,550.00	2,020,000.00
2037-11-21	180.00	2,020,000.00	27,775.00	2,047,775.00	0.00
Нийт		51,800,000.00	9,563,354.17		

Зээлдүүлэгчийг төлөөлж:

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн
дарга

С.Тулга

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
Санхүүгийн хөрөнгийн удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн

А.Гүнбилиг


Эцсийн зээлдэгчийг төлөөлж:

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал

Б.Бат-Эрдэнэ

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн
ерөнхий няглан бодогч

Б.Зулцэцэг



**Сангийн яам болон "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК хооронд байгуулсан
"Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл"-ийн дамжуулан зээлдүүлэх зээлийн
гэрээний хавсралт 2**

Нөхөн төлөх хүүгийн төлбөрийн хуваарь


Нөхөн төлөх хүүгийн төлбөр: 4,708,986.92

/ам.доллар/


Огноо	Нөхөн төлөх хүүгийн төлбөр	Үлдэгдэл
2024-12-31	-	4,708,986.92
2025-05-21	784,831.00	3,924,155.92
2025-11-21	784,831.00	3,139,324.92
2026-05-21	784,831.00	2,354,493.92
2026-11-21	784,831.00	1,569,662.92
2027-05-21	784,831.00	784,831.92
2027-11-21	784,831.92	0.00

Зээлдүүлэгчийг төлөөлж:

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн
дарга


С.Тулга

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн


А.Гүнбилиг

Эцсийн зээлдэгчийг төлөөлж:

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц"
ТӨХК-ийн гүйцэтгэх захирал


Б.Бат-Эрдэнэ

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц"
ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч


Б.Зулцэцэг

Сангийн яам болон "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК
хооронд байгуулсан "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын
өргөтгөл төсөл"-ийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний
хавсралт 3

Нөхөн төлөх хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөрийн хуваарь

Нөхөн төлөх дүн: 203,862.68

/ам.доллар/

Огноо	Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр	Үлдэгдэл
2024-12-31		203,862.68
2025-11-21	25,400.00	178,462.68
2026-05-21	25,400.00	153,062.68
2026-11-21	25,500.00	127,562.68
2027-05-21	25,500.00	102,062.68
2027-11-21	25,500.00	76,562.68
2028-05-21	25,500.00	51,062.68
2028-11-21	25,500.00	25,562.68
2029-05-21	25,562.68	0.00

Зээлдүүлэгчийг төлөөлж:

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн
дарга



С.Тулга

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
Санхүүгийн хөрөнгийн удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн


А.Гүнбилиг

Эцсийн зээлдэгчийг төлөөлж:

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал




Б.Бат-Эрдэнэ

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн
ерөнхий нягтлан бодогч


Б.Зулцэцэг